



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 5/09

Ховд

Г.Өөдэйд нууцын нэмэгдэл
олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт (Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам)-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Г.Өөдэйд Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журмын дагуу нууцын нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хувиар тооцон 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгосугай.

2. Г.Өөдэйд олгох нууцын нэмэгдлийг албан тушаалын сарын үндсэн цалингаас тооцон сар бүр бодож олгохыг Санхүүгийн хяналт, аудитын албаны нягтлан бодогч (Э.Сүхтулга)-д зөвшөөрсүгэй.

3. Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмыг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Г.Өөдэйд үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн (Нэмэгдэл хөлс олгох тухай) А/377 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



D/Zah-5/09-Bo
8400 01 0701